

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Гурванзагал сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2026 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Нармандах
Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Ө.Сийлэгмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: siilegmaau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.4.2 Авлага.....	11
3.4.3 Бараа материал	Error! Bookmark not defined.
3.4.4 Үндсэн хөрөнгө	Error! Bookmark not defined.
3.4.5 Засгийн газрын хувь оролцоо	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.5.1 Төсвийн төлөвлөлт	Error! Bookmark not defined.
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
3.5.3 Нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1 Албан шаардлага	
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2025 03 25 № 428
танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ДОРЖБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Гурванзагал сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 262.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Гурванзагал Хөгжил” орон нутгийн өмчит газар нь сүүлийн 3 жил дараалан алдагдалтай ажилласан байна. Мөн “Гурванзагал Хөгжил” орон нутгийн өмчит газрын даргыг 9 сард чөлөөлсөн боловч дараагийн даргыг томилоогүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд сумын Засаг дарга гарын үсэг зурсан байна.

2126050234

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Бусад асуудлын хэсэг

Гурванзагал сумын Засаг даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 89.3 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	580,063.3	837,642.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	265,352.8	402,981.6
33	АВЛАГА	150,710.4	203,226.5
35	БАРАА МАТЕРИАЛ	122,640.1	127,094.1
36	НӨӨЦИЙН БАРАА	41,360.0	104,340.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,172,915.9	2,112,223.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,172,915.9	2,112,223.0
39200	Биет хөрөнгө	2,152,465.9	2,092,073.0
39300	Биет бус хөрөнгө	20,450.0	20,150.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,752,979.2	2,949,865.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	50,909.9	130,676.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,909.9	130,676.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,702,069.3	2,819,188.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,702,069.3	2,819,188.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	358,325.5	338,525.5
51200	Хуримтлагдсан үр дүн	2,098,115.4	2,217,874.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245,628.4	242,988.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,752,979.2	2,949,865.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,645,735.8	3,300,850.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	470,618.6	429,321.2
110	Орлогын албан татвар	338,943.6	342,825.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	357,721.2	362,825.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(18,777.6)	(20,000.0)
113	Хөрөнгийн албан татвар	126,482.1	83,259.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,192.9	3,236.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,175,117.2	2,871,529.1
120	Нийтлэг татварын бус орлого	346,435.8	243,381.9
122	Тусламжийн орлого	2,828,681.4	2,628,147.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,005,084.5	2,842,967.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,005,084.5	2,806,047.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,525,856.5	1,416,964.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,100.5	812,713.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,898.5	108,666.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,605.3	152,315.4
2104	Хангамж, бараа материалын зардал	68,232.5	42,959.8
2105	Нормативт зардал	-	1,450.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,395.0	26,131.3
2107	Томилолт, зочны зардал	11,460.0	10,580.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,982.2	5,896.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	408,182.5	256,252.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,479,228.0	1,389,082.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	36,920.0

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Гурванзагал сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	640,651.3	457,882.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	635,051.2	338,124.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(V)	5,600.2	119,758.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,696,469.1		2,696,469.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,696,469.1		2,696,469.1
9	Тайлант үеийн үр дүн	5,600.2		5,600.2
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,702,069.3		2,702,069.3
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,702,069.3		2,702,069.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	242,988.4		242,988.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,945,057.7		2,945,057.7
19	Тайлант үеийн үр дүн	(125,869.5)		(125,869.5)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,819,188.2		2,819,188.2

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,391,600.4	3,117,771.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	470,618.6	429,321.2
110	Орлогын албан татвар	338,943.6	342,825.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	357,721.2	362,825.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(18,777.6)	(20,000.0)
113	Хөрөнгийн албан татвар	126,482.1	83,259.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	5,192.9	3,236.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,700.7	745.3
1181	Газрын төлбөр	3,492.2	2,491.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,920,981.9	2,688,450.7
120	Нийтлэг татварын бус орлого	92,300.5	135,026.4
122	Тусламжийн орлого	2,828,681.4	2,553,424.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,765,861.1	2,591,354.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,765,861.1	2,591,354.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,286,633.1	1,202,272.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,100.5	812,595.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,979.0	100,510.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,779.6	151,025.6
2104	Хангамж, бараа материалын зардал	51,285.7	39,105.7
2105	Нормативт зардал	-	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,735.0	40,459.4
2107	Томилолт, зочны зардал	11,460.0	10,580.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163,982.2	5,896.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,311.1	41,099.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,479,228.0	1,389,082.5

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Гурванзагал сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	625,739.3	526,417.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	606,610.2	308,788.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	606,610.2	308,788.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(606,610.2)	(308,788.5)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	80,000.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(80,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	19,129.1	137,628.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	246,223.7	265,352.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265,352.8	402,981.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,010,875.7	2,967,763.5
11	Татварын орлого	378,750.0	429,321.2
110	Орлогын албан татвар	306,750.0	342,825.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	326,750.0	362,825.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,000.0)	(20,000.0)
113	Хөрөнгийн албан татвар	68,000.0	83,259.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,000.0	3,236.6
12	Татварын бус орлого	2,632,125.7	2,538,442.3
120	Нийтлэг татварын бус орлого	29,044.9	54,208.0
122	Тусламжийн орлого	2,237,904.4	2,128,187.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	365,176.4	356,047.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,915,986.8	2,910,052.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,261,122.6	2,526,939.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,254,122.6	1,204,195.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	816,606.2	812,595.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,185.6	100,510.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,367.2	151,025.6
2104	Хангамж, бараа материалын зардал	44,439.4	36,643.2
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,908.4	46,135.4
2107	Томилолт, зочны зардал	11,660.0	10,580.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,786.8	5,871.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,169.0	39,833.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,000.0	1,322,744.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	544,864.2	303,112.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	110,000.0	80,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	264,624.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	397,058.2

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	70	66
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	2
610001	Төсвийн байгууллага	4	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	33	32
620001	Удирдах ажилтан	11	11
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	8	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,726.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,726.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,851.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,851.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,851.9
2104	Хангамж, бараа материалын зардал	1,586.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,265.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,265.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	874.121

3

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 16.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, харьяа байгууллагуудын зөрчлийн дүн 262.2 сая төгрөгт хүрч, залруулагдаагүй үлдсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 219.0 сая төгрөгөөр давсан тул *Хязгаарлалттай* дүгнэлт өгөв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Сумын татварын орлого нийт дүнгээрээ 115.9 хувиар биелсэн ч хөрөнгийн орлого 13.8 сая, ҮХЭХ-ын татвар 1.6 сая, торгуулийн орлого 1.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 81.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: *Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх* 15.0 сая төгрөгийн 2 ажил, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 170.3 сая төгрөгийн 6 ажил тус тус хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй	1	0					1	0				
Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлж ажиллаагүй	1	16.6					1	16.6				
Дүн	2	16.6			0	0	2	16.6				